



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/Б

Чойр

“Аймгийн гоц мэргэн” цол олгох
тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.7, 12.9, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн 03 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн баяр наадмын үндэсний шагайн харваанд тав болон түүнээс дээш удаа шалгарч амжилт үзүүлсэн Шивээговь сумын Бэхт багийн харваач Ганбаатарын Түвшинтамир, Одхүүгийн Эрдэнэбаяр, Баянтал сумын Лүн багийн харваач Лхагвасүрэнгийн Гантөгс нарт “Аймгийн гоц мэргэн” цол олгож, зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.


2. Шагналд зарцуулагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Т.Баясгалан), Говьсүмбэр аймгийн шагайн харвааны салбар холбооны тэргүүн (Б.Анхбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ



Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дүгээр сарын 25-ны өдрийн
А/З.З дугаар захирамжийн
хавсралт

“АЙМГИЙН ГОЦ МЭРГЭН” ЦОЛ, ТЭМДЭГ ОЛГОХОД
ЗАРЦУУЛАХ ТӨСӨВ

№	Алдарт уяач	Гаргасан амжилт	Материалын нэр	Нийт үнэ
1.	Ганбаатарын Түвшинтамир	Аймгийн баяр наадмын үндэсний шагайн харваанд багийн төрлөөр эхний гурван байрт таван удаа шалгарсан.	Үнэ бүхий дурсгалын зүйл	1,000,000
2.	Одхүүгийн Эрдэнэбаяр	Аймгийн баяр наадмын үндэсний шагайн харваанд багийн төрлөөр эхний гурван байрт таван удаа шалгарсан	Үнэ бүхий дурсгалын зүйл	1,000,000
3.	Лхагвасүрэнгийн Гантөгс	Аймгийн баяр наадмын үндэсний шагайн харваанд багийн төрлөөр эхний гурван байрт таван удаа шалгарсан	Үнэ бүхий дурсгалын зүйл	1,000,000
Нийт				3,000,000 /гурван сая төгрөг/

(
7

3
3
3